

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
218 дугаар тогтоолын 31 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
Боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

2025.05.21

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн яам

Нэгжийн нэр:

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын
Халдварт бус өвчний хэлтэс

Албан тушаалын нэр:

Амны хөндий, нүд, сонсголын эрүүл
мэнд хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Амны хөндий, нүд, сонсголын эрүүл мэнд, эрүүл ахуй, тархвар судлал, хүүхдийн эрүүл
ахуйн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт, удирдлага зохион байгуулалтаар хангах чиг
үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Амны хөндий, нүд, сонсголын эрүүл мэндийн урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт
2. Амны хөндий, нүд, сонсголын эмгэгийн тандалт, судалгааны нэгдсэн зохион байгуулалт, хүүхдийн эрүүл ахуйн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт
3. НЭМ-ийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг татан оролцуулах нөлөөллийн бодлогын хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт
4. Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээтэй холбоотой нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт
5. Хариуцсан асуудлаарх тандалт, судалгаа хийх, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, хууль, тогтоомж, стандарт, заавар, нэгдэн орсон олон улсын конвенцийн хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт, тайлагналт, тухайн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт;
6. Хариуцсан асуудлаарх салбар дундын хамтын ажиллагааг хангах, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж бүрдүүлж, хүлээлгэн өгөх үйл ажиллагаа;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Амны хөндий, нүд, сонсголын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлогын хэрэгжилтийн хангах;	Төсөл нь хуульд нийцсэн хэл зүй, найруулгын алдаагүй, ойлгомжтой байна	Г
		Хэрэгжилтийг хангаж ажилласан байна	Г
	2. Амны хөндий, нүд, сонсголын эрүүл мэндийг дэмжих талаар мэргэшлийн арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах;	Хууль тогтоомж хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна	Г
		Хяналт шалгалт хуулийн дагуу хийгдсэн байна	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Эрүүл ахуй, тархвар судлал, тандалт судалгааны чиглэлээр бодлогыг хэрэгжүүлэх, арга хэмжээ төлөвлөх;	Бодлогын хэрэгжилтийг хангасан байна.	Г
	2. Эрүүл ахуй, тархвар судлал, тандалт чиглэлээр арга	Гүйцэтгэлд хяналт тавьж, тайлан гаргасан байна.	Г

	хэмжээний гүйцэтгэлд хяналт тавих;		
	3. Хүүхдийн эрүүл ахуй, эрүүл аюулгүй орчинд амьдрах, бүрдүүлэх чиглэлээр бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах;	Бодлогын арга хэмжээ зохион байгуулсан байна.	Г
	4. Хүүхдийн эрүүл ахуй, эрүүл аюулгүй орчинд амьдрах, бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээг, хяналт тавих;	Хяналт тавьж, тайлан гаргасан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.НЭМ-ийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг татан оролцуулах нөлөөллийн чиглэлээр бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах;	Бодлогын арга хэмжээ зохион байгуулсан байна.	Г
	2. Олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг татан оролцуулах чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээг, хяналт тавих;	Хяналт тавьж, тайлан гаргасан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээтэй холбоотой бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах;	Бодлогын арга хэмжээ зохион байгуулсан байна.	Г
	2.Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээтэй холбоотой ажлыг зохион байгуулагдсан арга хэмжээг, хяналт тавих;	Хяналт тавьж, тайлан гаргасан байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Тухайн асуудлын чиглэлээр салбарын, салбар хоорондын болон олон улсын хамтын ажиллагааны нэгдсэн зохицуулалт хийх, хяналт тавих;	Хамтын ажиллагаанд зохицуулалт хийж, хяналт тавьсан байна.	Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.Хариуцсан асуудлын хүрээнд яамны болон төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Нэгжийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан эсэхэд хяналт тавьж, дүгнэсэн байна.	Г

2.Удирдлагууд болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;	Мэдээлэл, мэргэжил арга зүйн туслалцаа нь хууль, тогтоомжинд нийцсэн бодитой байна.	Г,Т
3.Архив, албан хэрэг хөтлөлт, тайлан, мэдээг цаг тухайд нь тайлагнах, хяналт тавих;	Албан хэргийн стандартын дагуу хөтөлсөн байна.	Г
4.Удирдлагаас хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байна.	Г,Т
5.Нэгжид ирсэн албан бичиг, өргөдөл, хүсэлтийг судалж, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулалтад хяналт тавих	Шийдвэрлэх үйл ажиллагаа хуульд нийсэн байна.	Х, Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	- нийтийн ариун цэвэр /102101/; - нийгмийн эрүүл мэнд /091801/; - эрүүл мэнд /091/.	
Мэргэшил		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх. - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;

		- саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох; - ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах - бусад.
	Бусад	- албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - англи хэл эсхүл гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологи ашиглах; - кирил болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах.


IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Халдварт бус өвчний хэлтсийн дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u>
	- Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, бусад төрийн байгууллагын газар, хэлтэс, нэгжийн холбогдох албан тушаалтан; - Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан; - Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  /Б.БАТБАЯР/ 2024 оны 12 дугаар сарын -ны өдөр	Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 25.05.21 Дугаар: 2189
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ Шийдвэрийн огноо: Дугаар: (тамга/тэмдэг) ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА..... /Д.ОЧИРБАТ/ 2025 оны ... дугаар сарын -ны өдөр	